



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 02 өдөр

Дугаар А/549

Номгон

Иргэн Л.Амгаланбаатарын эзэмшил газрын  
зориулалтыг өөрчлөх тухай


Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Газрын харилцаа, геодези, зурагзүйн газрын даргын 2008 оны 83 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ын 3.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Иргэн Л.Амгаланбаатарын (ВЭ83032917) хүсэлтийг харгалзан Баянхонгор сумын Номгон 1 дүгээр баг Тээвэрчдийн гудамж-3, 311 тоот хаягт байрлах 6409009142 нэгж талбарын дугаар бүхий Үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газрын зориулалттай 625 м2 газрын зориулалтыг худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор болгон өөрчилсүгэй.

2.Зориулалт өөрчлөгдсөнтэй холбогдуулан газрыг улсын бүртгэлд бүртгэн гэрчилгээ олгож, гэрээний биелэлтийг жил бүр дүгнэн ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл), Улсын бүртгэлийн хэлтэс (Д.Мөнхжаргал) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Эзэмшил газрын 10 хувийг цэцэрлэгжүүлэн зориулалтын дагуу зүй зохистой эзэмшихийг иргэдэд үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН